



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НЭГДСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

2023 он
Алтай хот

<p>Тайлан бэлтгэсэн: Дарга, тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр</p> <p>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг</p> <p>Ахлах аудитор: Б.Цэвэлмаа</p> <p>Аудитор: С.Санчирмаа Н.Гэрэлмаа</p> <p>2023 оны 4 дүгээр сар Уг тайланг ГАА-ийн Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn</p> <p>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7048-4030 дугаарын утсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын байр</p>	<p>АГУУЛГА</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 3</p> <p>Аудитын зорилт..... 3</p> <p>Аудитын хамарсан хүрээ 3</p> <p>Аудитын арга зүй..... 3</p> <p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа..... 3</p> <p>ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 3</p> <p>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ..... 4</p> <p>БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ..... 8</p> <p>БҮЛЭГ 3. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... 10</p> <p>БҮЛЭГ 4. ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ 10</p> <p>ДҮГНЭЛТ 11</p> <p>САНАЛ..... 12</p>
--	---

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4² дахь заалтын дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аудитын зорилт

Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлд дараах бүрэлдэхүүнээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн 2022 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
- Орон нутгийн 2022 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- Нэмэлт төсвийн 2022 оны гүйцэтгэлийн тайлан
- Төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлт

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000, Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн болон бусад холбогдох хэлтэс, сумдын төсөвт байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэвэлмаа, аудитор С.Санчирмаа, Н.Гэрэлмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Говь-Алтай аймгийн 2022 оны татварын ба татварын бус орлого, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдсэн эх үүсвэрийг орон нутгийн төсвийн 29, тусгай зориулалтын 76 байгууллага, орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, замын сан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ зэрэг зардлыг санхүүжүүлэхээр нийт 51,592.3 сая төгрөгийн орлого төлөвлөж, гүйцэтгэлээр 44,508.1 сая төгрөг зарцуулжээ. Аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагыг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолоор 49,469.9 сая төгрөгөөр баталсныг

¹ 8.1. Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

² 8.9.4.аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

төсвийн тодотголоор 2,123.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бөгөөд төсвийн нийт орлогын гүйцэтгэл 79.4 хувь, зарлагын гүйцэтгэл 86.3 хувьтай гарсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны төсвийн саналыг онлайнд суурилсан FISCAL-B системээр хүлээн авсан байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын тухайн жилийн нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, түүнд нийцүүлсэн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуулиар тус тус зохицуулдаг.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журам, аймгийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрхзүйн актуудыг үндэслэн төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 4.1.8-д “жилийн төсвийн хязгаар гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг”, 8.3.3-т “Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор батлах”, 8.3.4-т “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 178 дугаар тогтоолоор “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны төсвийн хязгаар”-ыг баталжээ. ТЕЗ нарын 2022 оны төсвийн хязгаарыг тогтооход дараах бодлого, чиглэл баримталсан байна. Үүнд:

- Төсөвт байгууллагууд төлөвлөсөн арга хэмжээг зайлшгүй хэрэгцээ шаардлага, үр дүн, ач холбогдлоор нь эрэмбэлж, төсөв хэмнэх горимд үргэлжлүүлэн ажиллах;
- Бүх шатны төрийн байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлэхийг дэмжиж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр шуурхай, нээлттэй ил тод, үр ашигтай, өгөөжтэй, хэмнэлттэй байдлаар иргэдэд хүргэх, төсвийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх;
- Татварын хамрагдалтыг нэмэгдүүлж, бүртгэл, үнэ шилжилтийн хяналтыг сайжруулж, татварын суурийг өргөжүүлэх;
- Төрийн өмчит компаниудын чиг үүрэг, бүтцийг шинэчлэн зохион байгуулж, засаглалыг сайжруулж, ашигт ажиллагаа, өгөөжийг нэмэгдүүлэн ил тод болгох;
- Чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж, төсвийн хуваарилалтын үр ашгийг сайжруулах;
- Хөрөнгө оруулалтын хэмжээг тогтвортой түвшинд хадгалж, эдийн засгийн идэвхжилийг үргэлжлүүлэн дэмжих;

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд үзүүлэлтэд нийцүүлэн орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагыг урьдчилсан байдлаар 2021 оны түвшинд тооцсон байна.

Хүснэгт 1. Орон нутгийн төслийг хянахад баримтлах суурь орлого, суурь зардлын хэмжээ /сая.төг/

ДД	Аймаг	Суурь орлого	Суурь зарлага	
			Төсвөөс санхүүжих	ОНХС-с санхүүжих
1	Говь-Алтай	10,793.7	28,639.6	527.0

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1³ дэх заалтад заасан цаглаврын дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарыг боловсруулж, төсвийн саналыг онлайнд суурилсан FISCAL-B системээр шивж оруулснаар Сангийн яам татан авч нэгтгэн Засгийн газарт төсвийн хязгаарыг хүргүүлдэг байна.

Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь орлогын дүнг 10,793.8 сая төгрөгөөр хянасан бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 27 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “2022 оны төсөв батлах тухай” тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 49,469.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2⁴-д заасан дагуу аймгийн ИТХ-ын “2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 63 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 51,592.3 сая төгрөг буюу 2,122.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Хүснэгт №2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт

/сая.төг/

№	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан дүн	2022 он		Анх батлагдсан дүнгээс өссөн/буурсан
			Анх батлагдсан	Тодотгол-3	
1	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	10,793.8	49,469.9	51,592.3	-2,122.4
2	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,793.8	49,469.9	51,592.3	-2,122.4
3	УРСГАЛ ОРЛОГО	10,793.8	11,258.1	13,017.1	-1,759.0
4	Татварын орлого	9,445.00	8,168.48	10,927.5	-2,759.0
5	Татварын бус орлого	1,348.79	3,089.62	2,089.6	1,000.0
6	ХӨРӨНГИЙН ОРЛОГО		1,275.48	1,275.48	0.0
7	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО		30,058.31	25,246.39	4,811.9
8	ӨМНӨХ ХЭМНЭГДСЭН ЗАРДАЛ, ТЭНЦЛИЙН АШИГ		-	3,766.49	-3,766.5
9	ӨМНӨХ ОНЫ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ		6,878.00	8,286.84	-1,408.8

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийг 39,539.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 4 хувиар буюу 1,432.9 сая төгрөгөөр илүү төвлөрүүлж, өмнөх оноос 35,487.6 сая төгрөгөөр буурсан. Нийт орлого ба тусламжийн орлогын 28 хувийг татварын, 72 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Хүснэгт 3. Орон нутгийн 2021 оны төсвийн орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	2021 он		2022 он		
	Гүйц	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	76,459.5	39,539.0	40,968.9	104%	1,432.9
Татварын орлого	9,086.0	10,927.5	11,607.6	107%	760.7
Орлогын албан татвар	7,272.3	7,478.1	8,149.2	109%	668.1
Хөрөнгийн албан татвар	754.9	1,712.5	1,856.9	109%	147.4
ААНОАТ		480.0	80.6		
Бусад татвар төлбөр хураамж	1,058.8	1,256.9	1,601.5	127%	344.6

³ Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх

⁴ “тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах.....”

Татварын бус орлого	67,373.5	28,611.5	29,280.7	102%	672.2
Нийтлэг бус татварын орлого	3,303.3	1,372.3	1,587.1	116%	214.8
Хөрөнгийн орлого	105.9	1,275.5	1,203.5	94%	-72.0
Тусламжийн орлого	119.5	717.3	1,510.9	211%	793.6
ОНХС-ийн нэгдсэн сангаас		10,142.7	9,878.5	97%	-264.2
Тусламж/ Шилжүүлэг	63,844.8	15,103.7	15,103.7	100%	0.0

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2022 оны 63 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд 2022 оны төсвийн нийт орлого, тусламжийн дүнг 51,592.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс 40,968.9 сая төгрөг буюу 79.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 903.4 сая төгрөгөөр давж биелсэн ч 9 нэр төрлийн орлого 1,041.8 сая төгрөгөөр тасарч, төлөвлөгөөнд тусгагдаагүй 3 нэр төрлийн 285.7 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Давсан орлогын талаар:

- Хувь хүний орлогын албан татварын орлого 775.1 сая төгрөгөөр давсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн шатлалд өөрчлөгдсөн, багш, эмч нарын цалинг гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсонтой холбоотой.
- Үйл ажиллагааны орлого 71.6 сая төгрөгөөр давсан нь малчдад олгосон арьс ширний урамшуулал, хонь, тэмээний ноосны урамшууллын татвар орсонтой холбоотой.
- Хөрөнгө борлуулсны орлого 24.3 сая төгрөгөөр давсан нь 2022 онд шинээр ашиглалтад орсон нийтийн орон сууцыг худалдан борлуулсны татварыг төвлөрүүлсэнтэй холбоотой.
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 243.9 сая төгрөгөөр давсан нь Тайшир-Гуулин УЦС-ын татварын маргаан шийдвэрлэгдэж актын төлбөрийг төвлөрүүлсэнтэй холбоотой.
- Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар 89.0 сая төгрөгөөр давсан нь аймгийн хэмжээнд 912 тээврийн хэрэгсэл шинээр нэмэгдсэнтэй холбоотой.

1.11 Орлогын төлөвлөгөөнд тусгаагүй дуудлага худалдааны орлогоос 280.0 сая төгрөг, ойн нөөц ашигласны төлбөрөөс 2.2 сая төгрөг, байгаль ургамлын нөөц ашигласны төлбөрөөс 0.2 сая төгрөг төвлөрүүлжээ.

Тасарсан орлогын тайлангаар:

- 1.12 Хөрөнгийн орлого 242.6 сая төгрөгөөр тасарсан нь арилжааны банкны хадгаламжийн хэмжээ буурснаас шалтгаалжээ.
- ААНОАТ-ын орлогоос орон нутгийн төсөвт хуваарилах 40%-ийн татварыг 480.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 80.6 сая төгрөг орж, 399.4 сая төгрөгөөр тасарсан нь орон нутгийн татварын бааз суурьд үндэслэлгүй хэт өндөр дүнгээр суурь орлогыг төлөвлөснөөс шалтгаалжээ.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хууль болон энэхүү хуулийг дагалдан батлагдсан “Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Хуулийн өөрчлөлтөөр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг орон нутгийн суурь орлогод шилжүүлсэн. Доорх хүснэгтээс харахад аймагт бүртгэлтэй аж ахуй нэгжийн 80-90 хувь нь жилийн 50 сая хүртэлх борлуулалтын орлоготой буюу бичил сегментэд харьяалагддаг, нийт бүртгэлтэй аж ахуй нэгжийн 40-55 хувь нь Х тайлан, алдагдалтай тайлан гаргаж байна. Аймгийн хэмжээнд 2022 онд 1524 аж ахуйн нэгжийн байгууллагын

орлогын албан татварын тайлан ирүүлэхээс 164 байгууллага огт тайлан ирүүлээгүй, 494 байгууллага Х тайлан илгээсэн байна.

Тухайлбал тайлант оны 377.2 сая ногдолтой тайлангаас 40 хувийг аймгийн төсөвт хуваарилна гэж тооцвол 150.8 сая төгрөг, нарийвчлан борлуулалтын орлогын эзлэх дүнгээр тооцвол үүнээс ч бага дүнгээр хуваарилагдахаар байх тул орон нутгийн орлогын төлөвлөгөөнд тусгасан 480.0 сая төгрөгийн төлөвлөгөө үндэслэлгүй байна.

Хүснэгт 4. ААНОАТ-ын тайлангийн судалгаа

№	Сегмент	Ирүүлбэл зохих тайлан	Ирүүлсэн тайлан	Ирүүлээгүй	Х тайлан	Алдагдалтай	Ногдолтой тайлан	Ногдолтой тайлан дүн /сая.төг/
1	Бичил	835	675	160	338	57	280	28.0
2	Жижиг	183	176	7	8	41	127	94
3	Дунд	1	1	0	0	1	0	-
	Нийт	1,019	852	167	346	99	407	122
1	Бичил	974	740	234	367	83	290	69
2	Жижиг	192	187	5	10	36	141	147
3	Дунд	2	0	2	0	0	0	-
	Нийт	1,168	927	241	377	119	431	216
1	Бичил	1,297	1,133	164	493	67	573	79
2	Жижиг	222	222	0	1	30	191	273
3	Дунд	5	5	0	0	2	3	26
	Нийт	1,524	1,360	164	494	99	767	377.2

Эх сурвалж: Аймгийн Татварын хэлтэс

Цаашид цахим төлбөрийн баримтын системд и баримт шивэлтийн дүнг нэмэгдүүлэх нь борлуулалтын орлогоо үнэн зөв тайлагнах, улмаар татварын орлого нэмэгдэх үндэслэл болохоор байна. Мөн дунд, том татвар төлөгчийн үйл ажиллагааны байршлыг нарийвчлан тогтоож, аймгаас эх үүсвэртэй олсон орлогыг орон нутгийн төсөвт хуваарилах нь зүйтэй байна.

- Малд ногдуулах албан татвар 122.7 сая төгрөгөөр тасарсан нь хуулийн хрээгжилтийн талаарх мэдээлэл, суртчилгааг иргэдэд хүргэх үйл ажиллагаа хангалтгүй, иргэдийн татвар төлөлт багассантай холбоотой байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 16.8 сая төгрөгөөр тасарсан нь Есөнбулаг суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Хан Алтай” ресурс ХХК-аас төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөлт хийсэн боловч тухай компаний үйл ажиллагаатай холбоотойгоор 2022 онд өрөөр тайлагнаж, 2023 оны эхний улиралд 20.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 100.2 сая төгрөгөөр тасарсан нь “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ болон “Алтай Улиастай ЭХС” ТӨХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу Есөнбулаг сумын айл өрхөөс авах хог хаягдлын үйлчилгээний хураамжийг гэрэл, цахилгааны төлбөртэй хамт авдаг байсан. Дээрх гэрээ цуцлагдсантай холбоотойгоор тухайн нэр төрлийн орлогыг төвлөрүүлэхээр тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тус хураамжийн орлогыг төрийн сан банк төвлөрүүлдэг тул иргэд гар утас болон интернет банк ашиглаж төлбөрөө төлөхгүй заавал арилжааны банкинд биечлэн очиж гүйлгээ хийж байсантай холбоотой байна. Тайлан оны 2 сараас эхлэн Хаан банкинд Төрийн үйлчилгээний 0 үлдэгдэлтэй данс нээж төвлөрсөн орлогыг 3 хоног тутамд Төрийн сангийн дансанд төвлөрүүлэхээр зохион байгуулжээ.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2.1 Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь зарлагын дүнг 29,505.1 сая төгрөгөөр хянасан бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “2022 оны төсөв батлах тухай” тогтоолд төсвийн ерөнхийлөн 49,469.9 сая төгрөгөөр баталсан байна.

2.2 Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Төсвийн тодотгол батлах тухай” 63 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “2022 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор орон нутгийн төсвийн суурь зардлыг 51,592.3 сая төгрөгөөр буюу 2,122.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан.

Хүснэгт 5 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт

/сая.төг/

№	Үзүүлэлт	Говь-Алтай аймаг			Анх батлагдсан дүнгээс өссөн/буурсан
		Сангийн яамны хянасан дүн	2022 он		
			Анх батлагдсан	Тодотгол-3	
	нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	29,505.1	49,469.9	51,592.3	-2,122.4
1	урсгал зардал	28,639.6	32,867.0	29,529.0	3,338.0
2	бараа, ажил үйлчилгээний зардал	27,572.4	31,144.1	27,713.9	3,430.2
3	хүү	58.1	0.0	0.0	0.0
4	татаас	1,009.0	7.8	100.0	-92.2
5	урсгал шилжүүлэг	0.0	1,715.1	1,715.1	0.0
6	хөрөнгийн зардал	865.5	14,545.1	20,005.6	-5,460.4
7	эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл		2,057.7	2,057.7	0.0
8	урсгал тэнцэл	-17,845.8	-21,608.9	-16,511.9	-5,097.0
	нийт тэнцэл	-18,711.3	0.0	0.0	0.0

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант оны орон нутгийн төсвийн нийт зарлага 44,508.1 сая төгрөг буюу 86 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 6. Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн

/сая төгрөг/

Үзүүлэлт	2021 он гүйц	2022 он			Зөрүү
		Төлөв	Гүйц	Хувь	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	72,570.1	51,592.3	44,508.1	86%	- 7,084.2
А. Урсгал зардал	64,515.0	29,529.0	26,457.7	1.83	- 3,071.3
Бараа, ажил үйлчилгээний зардал	62,892.1	27,713.9	24,749.5	89%	- 2,964.5
Хүү		0.0	0.0		-
Татаас	20.0	100.0	100.0	100%	- 0.0
Урсгал шилжүүлэг	1,602.9	1,715.1	1,608.3	94%	- 106.8
Б. Хөрөнгийн зардал	6,957.9	20,005.6	16,861.1	84%	- 3,144.5
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	1,097.2	2,057.7	1,189.3	58%	- 868.4

Эх сурвалж: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 59 хувийг урсгал, 38 хувийг хөрөнгийн, 3 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

Хөрөнгийн зардал өмнөх оноос 9,903.2 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 92.1 сая төгрөгөөр өсөж, урсгал зардал 38,057.3 сая төгрөгөөр буурч, нийт зардал 39 хувиар буурсан нь байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан орон нутгийн төсвийн суурь зарлагад тооцогддог зарим чиг үүргүүд нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (МУЗЗНДНТУТ)-ийн 27 дугаар зүйлд зааснаар засаг захиргааны нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэгт шилжсэнтэй холбоотой. Тухайлбал, орон нутгийн төсвийн суурь зарлагын дийлэнх хувийг эзэлдэг нийгмийн халамж, үйлчилгээ, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, соёлын үйлчилгээ зэрэг чиг үүрэг орон нутгийн суурь зарлагад тооцогддог байсан бол шинэ хуулиар тусгай зориулалтын шилжүүлэг болж өөрчлөгдсөнөөр орон нутгийн суурь зарлага буурсан байна

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөд 2,057.7 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,189.3 сая төгрөг төвлөрүүлсэн нь сангаас зээл авсан иргэд, аж ахуйн нэгжүүд хугацаандаа зээлээ төлөөгүйтэй холбоотой байна. Прокурорын газарт “Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 137 зээлдэгчтэй холбоотой 192.9 сая төгрөгийн зээлийн төлөлт хийгдээгүй төр хохирч байгаа үйлдэл”-д төрийг төлөөлж хохирлыг барагдуулах албан бичгийг хүргүүлэхэд бэлэн болоод байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд нь удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр 56.4 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгож, буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон байна.

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төсвийн ерөнхийлөн захирагч дараах арга хэмжээ авсан байна.

Аймгийн Засаг даргын “Төсвийн ил тод байдлыг хангаж, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх тухай” 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэхээр баталсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.1⁵, Засгийн газрын 204 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/576 дугаартай “Орон нутгийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг хүлээлгэн өгөх ажлын хэсэг байгуулах тухай” захирамж гарсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 59 дүгээр тушаалаар орон нутгийн өмчит байгууллагуудын 25 автотээврийн хэрэгслийг худалдан борлуулахаар шийдвэр гарсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг үзэхэд дараах нийтлэг зөрчил илэрсэн. Үүнд:

- Засаг даргын зөвлөх, орлогчийн орон тоонд илүү ажиллуулж 18.2 сая төгрөгийн цалин олгосон
- Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчдад дэмжлэгийг тэтгэмжтэй давхардуулан 2.4 сая төгрөгийг олгосон.
- Төрийн хэмнэлтийн горим зөрчиж хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр 472.5 сая төгрөгийн шагнал урамшуулал олгосон.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн хэмнэлтийн горим зөрчиж 160.9 сая төгрөгийг шагнал урамшуулал, бэлэг дурсгалын зүйлст зарцуулсан
- Иргэдэд 293.1 сая төгрөгийн дэмжлэг олгосон

⁵ Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

- Төрийн хэмнэлтийн горим зөрчиж 3.3 сая төгрөгийн тээвэр, шатахуун зарцуулсан
- Нэгдсэн халаалтын системд холбосон боловч дулааны тоолуур ашиглаагүй
- Байгууллагын авто тээврийн хэрэгсэл нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, төсөв захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт төсөвт төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 1,110.0 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 185.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 839.6 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 342.7 сая, нийт 2,477.6 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн нэмэлт санхүүжилтийн орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөж, нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан нь төсвийн хяналтыг сулруулах эрсдэлтэй байна. Тухайлбал:

Нэмэлт төсвийг зарцуулахдаа цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 78.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 6.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 4.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 202.0 сая төгрөг, норматив зардалд 23.0 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 116.2 сая төгрөг, томилолтын зардалд 67.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1,191.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 722.8 сая төгрөг, тэтгэмж шагнал урамшууллын зардалд 3.5 сая төгрөгийг зарцуулж, улс, орон нутгийн төсөвт 157.0 сая төгрөгийг төвлөрүүлж, сумдын Эрүүл мэндийн төвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 95.1 сая төгрөгийн эхний үлдэгдлийг улсын төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлсэн байна.

Нэмэлт орлогоос Төсвийн тухай хуулийн 46.5.1⁹-д заасан хориглох арга хэмжээнд зарцуулсан зарцуулалт байхгүй байна.

БҮЛЭГ 4. ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ

Төрийн аудитын байгууллага нь тооцоо, судалгаандаа үндэслэн 2022 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх 8 төрлийн 1,429.5 сая төгрөгийн, төсвийн зардал буруулах 142.3 сая төгрөгийн, үр ашиг нэмэгдүүлэх 6 санал өгчээ.

Орлого нэмэгдүүлэх саналын хүрээнд:

- Газрын төлбөрийн орлогыг 458.2 төгрөгөөр нэмэгдүүлэх санал өгсөн, гүйцэтгэлээр 456.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн,
- Газрын дуудлага худалдааны орлогыг 68.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр санал өгсөн, гүйцэтгэлээр 280.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн,
- Усны төлбөрийн орлогыг 101.6 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэхээр санал өгсөн, гүйцэтгэлээр 128.7 сая төгрөгийн төвлөрүүлсэн байна.
- Түрээсийн орлогоос 10.5 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх боломжтой санал өгсөн, гүйцэтгэлээр 10.6 сая төгрөг төвлөрсөн байна.

- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг 294.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал өгсөн, гүйцэтгэлээр 45.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. “Алтайн-Хүдэр” ХХК үл хөдлөх хөрөнгийн албан татварын 154.7 сая төгрөгийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
- Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Мал хамгаалах сангаас олгосон зээлээс гэрээний хугацаа дууссан иргэд аж ахуйн нэгжүүдээс 211.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжтой санал өгсөн, гүйцэтгэлээр 74.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн,
- Нэр заагдаагүй орлого буюу УИХ-ын гишүүний багцаас олгосон зээлээс гэрээний хугацаа дууссан иргэд аж ахуйн нэгжүүдээс 433.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжтой санал өгсөн, гүйцэтгэлээр 32.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь зээлдэгч хугацаандаа зээлээ төлөхгүй, зээлийг төлүүлэх арга хэмжээ авахгүй байгаатай холбоотой байна. Мөн аймгийн ЗДТГ-аас 16 зээлдэгчтэй холбоотой 166.7 сая төгрөгийг төлбөр авагч аймгийн Засаг даргын Тамгын газрын албан бичгээр хүсэлт хүргүүлж гүйцэтгэх хуудсыг буцаан авсан зөрчил илэрч 2022 онд хийсэн аудитаар албан шаардлага хүргүүлсэн.

Зардал бууруулах саналаас 22.1 сая төгрөгийг хүлээн авч зардлыг бууруулжээ. Харин үр ашиг нэмэгдүүлэх 6 саналаас 5 саналыг нь хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Орон нутгийн төсвийн төсөлд орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ бүрд зураг төсөв, ажлын даалгавар, техникийн нөхцөлийг тусгасан байна.
- Тусгай сангийн орлогод тооцсон 1,000.0 сая төгрөгийг хэрхэн бүрдүүлэх нь тодорхойгүй, нотлох баримтгүй хийсвэр дүнгээр тооцоог хийсэн байсан. Үр ашгийн саналын хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тус сангийн журмыг батлуулахаар Хууль зүйн яамд хүргүүлсэн боловч хэм хэмжээний актаар бүртгээгүй хасах тодотгол хийхээр төлөвлөсөн байна.
- Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх зардалд 7,361.4 сая төгрөгийг зарцуулах тооцоолсон байсан. Гэтэл төрийн байгууллагад ажиллаж байгаа 867 албан хаагчийн нийгмийн хамгаалал, тогтвортой ажлын байр, ажилгүйдлийн түвшнийг тооцоогүй, гүйцэтгэгч төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулаагүй байсан. Үр ашгийн саналын хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 сарын 02-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор Үйлчилгээний нэг ажилтны ажлын хөлсний доод жишиг тарифыг баталсан боловч УИХ-аар нэгдсэн төсвийн гүйцэтгэлд тодотгол хийж, аймгийн төсвийн санхүүгийн дэмжлэгийг бууруулж, харьяа яаманд үйлчилгээний ажилтнуудын холбогдох зардлуудыг шилжүүлсэн байна.
- “Хүнхэр зуслан”-г 180.0 сая төгрөг, “Гэгээн нуур цэвэр ус” ААТҮГ-г 475.0 сая төгрөгөөр хувьчлахаар тусгасан нь барилга байгууламжийн бодит үнэ цэнийг үнэлээгүй, мэргэжлийн байгууллагын санал зөвлөмжийг тусгаагүй байсан. Үр ашгийн саналын хүрээнд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэн хөрөнгийг худалдан борлуулсан байна.

ДҮГНЭЛТ

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, төсөв захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.
2. Орон нутгийн 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 1,041.8 сая төгрөгөөр тасарсан байна.

3. Аймгийн хэмжээнд 2022 онд 1524 аж ахуйн нэгжийн байгууллагын орлогын албан татварын тайлан ирүүлэхээс 164 байгууллага огт тайлан ирүүлээгүй, 494 байгууллага Х тайлан илгээсэн байна.
4. Засгийн газрын тусгай сангийн хувьд зээлийн эргэн төлөлтийг гэрээний хугацаанд төлүүлэх, хугацаа дууссан зээлийн авлагыг барагдуулах талаар санаачилгатай ажиллаагүй байна.

САНАЛ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ:

Монгол Улсын төсвийн гүйцэтгэлийн тайланд дараах асуудлыг тусгуулах саналтай байна. Үүнд:

- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогын төлөвлөгөөг орон нутгийн татварын бааз суурьт үндэслэн тооцоолж, төлөвлөх
- Дунд, том татварын төлөгчийн үйл ажиллагааны байршлыг нарийвчлан тогтоож, аймгаас эх үүсвэртэй олсон орлогыг орон нутгийн төсөвт хуваарилах

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт зөвлөж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэхэд төрийн сангийн хяналтыг сайжруулж, төсөв захирагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэхэд үзүүлэлт болгон оруулж сахилга хариуцлагыг дээшлүүлэх.
- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй, тооцоо судалгаатай боловсруулах
- Засгийн газрын тусгай сангийн зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд нь төлүүлж, хугацаа дууссан зээлийн авлагыг барагдуулах талаар эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, барагдуулах арга хэмжээг зохион байгуулах

ЗӨВЛӨМЖ: Татварын хэлтэст:

- Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайланг ирүүлээгүй, үйл ажиллагаа явуулаагүй байгууллагад хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

